

ШИНЭСТ ХК

## ШИНЭСТ ХК

Бүртгэлийн дугаар: 2018942  
МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР  
Хан-Уул дүүрэг, 3-р хороо  
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс  
Утас: 70114414, 88818333  
И-мэйл: shinest4414@gmail.com

2024 оны 05-р сарын 15-ны өдөр

Дугаар 24/12

Улаанбаатар хот


### Хувьцаа эргүүлэн худалдан авах тухай

“Шинэст” ХК нь “Компанийн тухай хууль”-ийн 76.1.6 болон 55.7, 55.8, 55.9 дүгээр зүйлийг тус тус үндэслэн шийдвэрлэх нь :

1. Шинэст ХК нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) болохтой холбоотой хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаатай холбоотой 33,758 (гучин гурван мянга долоон зуун тавин найм) ширхэг хувьцааг олон нийтээс худалдан авах санал гаргахаар шийдвэрлэсүгэй.
2. Тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан хувьцааг худалдан авах тухай саналын худалдан авах үнийг 33,802.2 (гучин гурван мянга найман зуун хоёр төгрөг хорин мөнгө) төгрөг байхаар баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх журмын хэрэгжилтийг хангаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг байгууллагуудтай харилцаж зохих зөвшөөрөл гэрээ байгуулах үйл ажиллагааг эхлүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Оюунтүлхүүр-т даалгасугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга: ...../Б.Бурмаа/





**ШИНЭСТ ХК**

## **ШИНЭСТ ХК**

Бүртгэлийн дугаар: 2018942  
МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР  
Хан-Уул дүүрэг, 3-р хороо  
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс  
Утас: 70114414, 88818333  
И-мэйл: shonest4414@gmail.com

2024 оны 05-р сарын 15-ны өдөр

Дугаар 24/13

Улаанбаатар хот

### **Хувьцааны нэгж үнийг тогтоосон үндэслэл**


“Шинэст ХК нь ХХК болохтой холбоотой хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаатай холбоотой 33,758 (гучин гурван мянга долоон зуун тавин найм ) ширхэг хувьцааг худалдан авах санал гаргахаар шийдвэр гаргасан билээ. Энэхүү шийдвэрийг гаргахдаа нэгж хувьцааны үнийг дараах байдлаар тогтоов.

Компаний тухай хуульд хувьцааны үнэлгээг тогтоох аргачлалыг тодорхой дурдсан байдаг ба Компанийн тухай хуулийн 55.7 -д дурдсан үнэлгээг үндэслэх ба тус хуулийн 55.8 дугаар хэсгийг харгалзан үзэх үүрэгтэй байдаг. Иймд бид Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн цэвэр өөрийн хөрөнгийн үнэ цэнэ болон сүүлийн 6 сарын хувьцааны жигнэсэн дундаж ханшийг харгалзан нэгж хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоолоо.

1. Компанийн тухай хуулийн 55.7-д "Хувьцаат компанийн хувьд энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тохиолдолд хувьцааны үнийг хараат бус үнэлгээний байгууллага, аудитын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тодорхойлно." гэж заасны дагуу хөрөнгийн дахин үнэлгээг балансад оруулж тооцсоноор нийт цэвэр хөрөнгө (NAV) 8,907,057,433.0 төгрөг буюу Нэгж хувьцаанд ногдох цэвэр хөрөнгө 48,218.45 төгрөг байна.
2. Компанийн тухай хуулийн 55.8-д "Нийтэд худалдагдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын болон бусад арилжааны албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзана." гэж заасны дагуу Шинэст ХК-ийн хамгийн сүүлд хувьцаа нь арилжаалагдсан огноо 2022.12.06-нд байгаа бөгөөд үүнээс хойшхи 6 сарын өмнөх Жигнэсэн дундаж ханш (VWAP) 164.26 төгрөг байна.

Мөн Компанийн тухай хуулийн 55.9-д "Компанийн хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, компанийн өөрийн хөрөнгө, ашиг зэргийн талаар бүрэн мэдээлэлтэй худалдан авагчийн санал болгосон боломжит үнэ болон бусад хүчин зүйлийг харгалзан үзнэ." гэж заасны дагуу,

худалдан авагч тал буюу Шинэст ХК-ийн хувьцааг эргүүлэн худалдан авах санхүүгийн нөөц боломж, одоогийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл зэргийг харгалзан үзэх юм. Нөгөө



ШИНЭСТ ХК

## ШИНЭСТ ХК

Бүртгэлийн дугаар: 2018942  
МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР  
Хан-Уул дүүрэг, 3-р хороо  
Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар, Монгол улс  
Утас: 70114414, 88818333  
И-мэйл: shinest4414@gmail.com

талаас жижиглэн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хараат бус үнэлгээний байгууллагын гаргасан үнэлгээнд илүү эзлэх жин харгалзуулж компанийн нэгж хувьцааг эргүүлэн худалдан авах үнийн дүнг доорх байдлаар гаргасан болно.

Ханш	Үнэ	Жин	Жигнэсэн дундаж ханш
Сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш	164.26	0.3	49.28
Нэгж хувьцаанд ногдох цэвэр хөрөнгө	48,218.45	0.7	33,752.92
<b>Эргүүлэн худалдан авах хувьцааны ханш</b>		<b>1.0</b>	<b>33,802.20</b>

Компанийн хувьд одоогоор модон эдлэл үйлдвэрлэх, бэлэн модон бэлдцийн бөөний худалдаа эрхлэх үндсэн үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа бөгөөд өөрийн объект, газар бүхий үндсэн хөрөнгөө түрээслэх байдлаар туслах үйл ажиллагааны орлогоос гол орлогын эх үүсвэрээ бүрдүүлдэг. Иймд компанийн нэгж хувьцааны үнийг тогтоохдоо дан барилга, газар гэсэн үндсэн хөрөнгийн үнэлгээнд суурилах нь учир дутагдалтай байгаа ба хөрвөх чадвар сул, 1978 онд ашиглалтанд орсон барилга тул компани үндсэн бизнесийн үр өгөөж олох боломж хомс байна. Гэвч хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс хамгийн өндөр үнэлгээтэй гарсан цэвэр хөрөнгийн аргаар тооцсон хувьцааны үнэлгээнд хамгийн өндөр жин харгалзуулсан. Мөн биржид бүртгэлтэй нээлттэй компанийн хувьцаа учир Компанийн тухай хуулийн 55.8-д заасны дагуу сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзан үзэх нь зүйтэй гэж дүгнэсэн болно.

Гүйцэтгэх захирал



/Э.Болор/